



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 694

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэрийн нийт 79,224,000.00 (далан есөн сая хоёр зуун хорин дөрвөн мянган) төгрөгийн балансын үнэ, 21,898,444.37 (хорин нэгэн сая найман зуун ерэн найман мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг гучин долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Барилга, хот байгуулалтын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ц.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007524

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
6⁹/ дугаар тогтоолын хавсралт

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			(ширхэг)				
					(төгрөг)		
1	Хьюндай соната 8, 01-58 УНВ, /LF2017/	3/22/2018	1	72,324,000.00	72,324,000.00	21,898,444.37	50,425,555.63
2	Архивын нягтруулсан шүүгээ	12/10/2021	6	1,150,000.00	6,900,000.00	-	6,900,000.00
НИЙТ ДҮН					79,224,000.00	21,898,444.37	57,325,555.63
					(далан есөн сая хоёр зуун хорин дөрвөн мянган)	(хорин нэгэн сая найман зуун ерэн найман мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг гучин долоон мөнгө)	(тавин долоон сая гурван зуун хорин таван мянга таван зуун тавин таван төгрөг жаран гурван мөнгө)